EXCHANGE**

2025

Annual

Санхүү, Үйл Ажиллагааны
Тайлан



ТУЗ-ийн даргын мэндчилгээ



Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Д. Баясгалан

(2025 оныг дуустал Гүйцэтгэх захирлаар ажилласан)

Хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагчид, түншүүд ээ.

2025 он Инвекс Корп Санхүүгийн Байгууллагын хувьд өсөлт, тэлэлт, бэхжилтийн зэрэгцээ стратегийн хувьд шинэ шатанд гарсан он байлаа. Тайлант хугацаанд бид үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлж, олон улсын хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, дижитал шилжилтийг эрчимжүүлэхийн зэрэгцээ тогтвортой санхүүжилтийн чиглэлд бодит ахиц дэвшил гаргалаа.

Бидний хувьд 2025 оны онцлох амжилтуудын нэг нь олон улсын зах зээлд нэвтрэх, санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх чиглэлд гарсан ахиц байв. FMO, Triodos зэрэг олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, урт хугацааны санхүүжилт татан төвлөрүүлсэн нь компанийн санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхээс бадна засаглал, ил тод байдал, хариуцлагатай санхүүжилтийн стандартыг шинэ түвшинд хүргэхэд чухал нөлөө үзүүлэв.

Бизнесийн үйл ажиллагааны хүрээнд бид дотоодын болон бүс нутгийн зах зээлд байр сууриа бэхжүүлж, салбарын тоог өргөжүүлэн, Киргизстан, Казахстан дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд хүчин чармайлт гаргасан жил байлаа. Энэ нь бүс нутагт чиглэсэн стратеги хэрэгжүүлэх, зах зээлийн эрсдэлийг төрөлжүүлэх, урт хугацааны өсөлтийн суурийг бий болгох чухал алхам болсон.

Дижитал шилжилтийн хүрээнд бид үндсэн системүүдээ шинэчлэх, автоматжуулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг хөгжүүлэх чиглэлд томоохон хөрөнгө оруулалтууд хийж, зээлийн үнэлгээ, үйл ажиллагааны үр ашиг, харилцагчийн туршлагыг мэдэгдэхүйц сайжрууллаа. Дижитал сувгуудын хөгжүүлэлт нь бидний ирээдүйн өсөлтийн гол хөдөлгөгч хүчин зүйл хэвээр байх болно.

Макро эдийн засгийн орчинд үүсэж буй тодорхойгүй байдал, инфляцын дарамт, зээлийн эргэн төлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг бид анхааралтай ажиглаж, эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бэхжүүлэн ажиллаж байна. Зээлийн багцын чанарыг хадгалах, эрсдэлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад онцгой анхаарч байна.

Тогтвортой хөгжлийн хүрээнд бид ногоон болон хүртээмжтэй санхүүжилтийг нэмэгдүүлэх, байгаль орчин, нийгмийн хариуцлагыг бизнесийн шийдвэр гаргалтад нэгтгэх чиглэлд тууштай ажиллаж байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчид, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь бидний стратегийн чухал хэсэг хэвээр байна.

2026 оны хэтийн төлөв байдал

2026 онд бид эдийн засгийн орчны сорилтуудыг даван туулахын зэрэгцээ эрсдэлийн зохистой түвшинд өсөлтийг хангах, дижитал болон ногоон санхүүжилтийг өргөжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд төвлөрч ажиллахын сацуу байгууллагын засаглал, шийдвэр гаргалт, үйл ажиллагааны үр ашгийг шинэ түвшинд хүргэх өөрчлөлтүүдийг үе шаттай хэрэгжүүлэх болно.

2026 он нь Инвекс Корп Санхүүгийн Байгууллагын хувьд 10 жилийн ойтойгоо золгож буй онцгой ач холбогдолтой жил юм. Энэхүү чухал үе шаттай уялдуулан бид байгууллагын хөгжлийн дараагийн үе шатыг тодорхойлж, удирдлагын арга барил, үйл ажиллагааны бүтэц, тогтолцоонд цогц шинэчлэл хийх сорилтыг дэвшүүлж байна.

Бид өнгөрсөн хугацаанд бүрдүүлсэн туршлага, суурин дээр тулгуурлан ирэх 10 жилийн стратегийг тодорхойлж, илүү уян хатан, өгөгдөлд суурилсан, эрсдэлийг урьдчилан тооцоолдог удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч ажиллана. Мөн дэлхийн болон бүс нутгийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй хурдацтай өөрчлөлтүүд, гадаад орчны нөлөөллийг даван туулах чадвартай, тэсвэртэй байгууллагын бүтцийг бий болгох нь бидний тэргүүлэх зорилт байна.

АГУУЛГА

- 1 Онцлох үйл явдлууд
- 2 Бизнесийн үйл ажиллагаа
- 3 Санхүүгийн үр дүн
- 4 Эрсдэлийн удирдлага
- 5 Тогтвортой хөгжил
- 6 Компанийн засаглал



01. 2025 оны онцлох үйл явдлууд





Лондонгийн Хөрөнгийн Биржид

Инвескор ББСБ ХК-ийн толгой компани болох ICFG LTD нь Лондоны Хөрөнгийн Биржид бүртгэлтэй анхны Монгол санхүүгийн компани болж, олон улсын зах зээлд шинэ алхам хийж баярт мөчөө харилцагчид, түншүүд болон хамтран ажиллагсадтайгаа хамт тэмдэглэлээ.



"ТОП-100 Аж Ахуйн Нэгж"- ээр шалгарлаа

Инвескор Санхүүгийн Байгууллагыг Монгол Улсын Засгийн газар болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас "ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖ"-ийн нэгээр анх удаа шалгарууллаа.



InvesCore FI

Орон нутгийн тэлэлт

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үндсэн зорилтуудынхаа хүрээнд Дорноговь аймаг, Өмнөговь аймагт тус тус өөрийн салбараа нээж, орон нутгийн бизнесийг хөгжүүлэх чиглэлд ажиллаж байна.



Киргиз улсад дахин нэг салбар нээлээ

Киргиз улс дахь Инвескорын охин компани Чуй бүсийн Токмок хотод шинэ салбараа байгуулав.



"Харилцагчийг хамгаалах зарчим"-ын Silver түвшний үнэлгээтэй сертификат авлаа

Бид 2022 оноос хойш Харилцагчийг хамгаалах зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үе шаттай сайжруулж ирсэн бөгөөд эдгээр зарчмуудын хэрэгжилтийг баталгаажуулахаар олон улсын түвшний MFR үнэлгээний агентлагаар хөндлөнгийн аудит хийлгэж SILVER түвшинд үнэлэгдлээ.



RioTinto × InvesCore FI

Жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөр

Инвескор Санхүүгийн Групп болон Rio Tinto-той хамтран хэрэгжүүлж буй "Жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн хаалтын үйл ажиллагаа амжилттай болж өндөрлөлөө.



Нидерландын Хөгжлийн Банкнаас 20 сая ам.долларын санхүүжилт татлаа

Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO)-аас 20 сая ам.долларын урт хугацаат зээлийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь ЖДБ санхүүгийн дэмжлэгээр хангаж, хүртээмжтэй санхүүгийн шийдлийг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.



ToC × InvesCore FI

"Онцлох ToC санхүүгийн байгууллага"-аар шалгарлаа

2025 онд үйл ажиллагаандаа тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт, харилцагчийг хамгаалах, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн санаачилгуудыг үнэлэн Тогтвортой Санхүүжилтийн Холбооны 2025 оны "Онцлох ToC Санхүүгийн Байгууллага"-аар Инвескор Санхүүгийн Байгууллага шалгарлаа.



02. Бизнесийн үйл ажиллагаа






Салбарын онцлогт тохирсон санхүүжилтийн шийдлүүд

Эдийн засгийн салбаруудын онцлогт нь тохируулан хамтрагч байгууллагуудтай хамтран хөдөө аж ахуйг дэмжсэн бүтээгдэхүүний зээл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах зээл, Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индексийн хувьцааг барьцаалсан зээл, болон импортын зээл зэрэг бусад олон төрлийн бүтээгдэхүүнийг харилцагчийнхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэвтрүүлээд байна.



Core Synergy VIP customer event

Компанийн стратегийн харилцагч болох VIP үйлчлүүлэгчдэдээ бизнесээ өргөжүүлэх, шинэ боломжуудыг нээхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор цуврал нэвтрүүлэг арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь салбар бүрийн гүйцэтгэх удирдлагын түвшний төлөөллүүдийг оролцуулан, туршлага солилцох, сүлжээг өргөжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлэх боломжийг бүрдүүлдгээрээ онцлогтой юм.



Бизнесийн зээлийг дэмжих “Боломжоо тэл” аян

Бизнесийг дэмжих бодлогын хүрээнд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн санхүүжилтийн аяныг “Боломжоо тэл” уриан дор амжилттай хэрэгжүүлж, Инвескорын экосистем дэх хамтын ажиллагааг өргөжүүлэн харилцагчдын бизнесийн өсөлтийг дэмжин ажиллалаа.



Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт

Ногоон бизнесийг дэмжих зорилгоор цахилгаан автомашин худалдан авах, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, цахилгаан бараа бүтээгдэхүүн худалдан авахад зориулсан зээлийн бүтээгдэхүүнүүдийг шинээр нэвтрүүллээ. Мөн Тогтвортой Санхүүжилтийн Холбоотой хамтран эмэгтэй бичил бизнес эрхлэгчдэд зориулсан ногоон батлан даалттай санхүүжилтийг хэрэгжүүлэх санамж бичиг байгуулж, уг санаачилгад ББСБ-ын салбарыг төлөөлөн оролцохоор болсон нь хүртээмжтэй, тогтвортой санхүүжилтийг дэмжихэд чухал алхам боллоо.



Стратегийн түншлэл

Голомт банктай хамтран Агент банк үйлчилгээг нэвтрүүлснээр Инвескор Санхүүгийн байгууллагын бизнес төвүүдээр дамжуулан арилжааны банкны данс нээх, карт захиалах, лавлагаа, мэдээлэл авах боломжтой боллоо.



pocket ZERO

Pocket Zero Expo 2025

BNPL үйлчилгээг сурталчлан таниулах зорилготойгоор жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг арга хэмжээг “Хайр ба Гэр бүл” концепцийн хүрээнд амжилттай зохион байгуулав.



pocket

Халаас дүүрэн инээмсэглэл

5 жилийн ойг хэрэглэгч, харилцагч, ажилтнууддаа баяр хүргэсэн байдлаар зохион байгуулав.



Pocket safe: Таны халаасан дахь сейф

Харилцагчдын хуримтлалын соёлыг дэмжих, санхүүгийн төлөвлөлтийг сайжруулах зорилгоор Pocket Safe итгэлцлийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэв. Тус бүтээгдэхүүн нь харилцагчдад хөрөнгийн өсөлтийн өгөөжийг өөрийн санхүүгийн зорилго, хугацаа, өгөөжийн сонголттой уялдуулан “Зорилтот, Ухаалаг, Уян, Өндөр дүнтэй” гэсэн дөрвөн төрлөөс сонгон ашиглах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр харилцагчид өөрийн орлого, зарлагын төлөвлөлтийг илүү оновчтой удирдах, хуримтлалаа тогтвортой өсгөх дижитал шийдлийг ашиглах боломжтой болсон.



Helicar сангийн 25 сая ам.долларын санхүүжилт

2018 онд байгуулагдсан Helicar сан нь Зүүн Өмнөд Азийн зах зээлд 400 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн, өгөгдөл суурилсан хөрөнгө оруулалтын шийдэл болон эрсдэлийн удирдлагын аргачлалаараа танигдсан платформ бөгөөд Pocket апп нь тэдний Монгол дахь анхны хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа болж байна. Энэхүү санхүүжилт нь Pocket апп-ийн үйлчилгээг өргөжүүлж, илүү олон хэрэглэгчдэд хүртээмжтэй, хариуцлагатай санхүүгийн үйлчилгээ хүргэх, шинэ бүтээгдэхүүн, инновацыг хөгжүүлэх, цаашлаад Монголын финтек шийдлүүдийг олон улсын зах зээлд гаргах стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болохоор байна.



Төв Ази дахь үйл ажиллагаа




InvesCore KG - Киргиз улс

Зээлийн Багц: **67.5 тэрбум ₮**

Салбарын тоо: **5**

Гадаа болон дотоодын санхүүгийн байгууллага, олон улсын сангуудаас нийт 2.7 сая долларын санхүүжилт татсан ба Lendahand-аас 1.5 сая долларын санхүүжилт авах гэрээнд гарын үсэг зурлаа.

Зээлийн багц (тэрбум төгрөг)



Үүний зэрэгцээ, InvesCore KG нь онлайн бичил зээлийн бүтээгдэхүүний 1-р үе шатны туршилтаар дижитал бүтээгдэхүүнээ нэвтрүүлж, өсөлтийн сууриа бэхжүүлсэн. Эдгээр амжилтаар 2025 онд InvesCore KG нь Киргиз улс дахь ББСБ-уудын зах зээлд 5-р байр эзэлж байна. Чуй бүсийн Токмок хотод шинэ салбараа байгуулав.




InvesCore KZ - Казахстан улс

Зээлийн Багц: **24.6 тэрбум ₮**

Салбарын тоо: **1**

Казахстан улс дахь Инвескор компанийн хувьд 2025 он эрчимтэй өсөлт, институцийн чадавх бэхжсэн жил байлаа. Хяналтын зөвлөлийг байгуулснаар компанийн засаглал сайжирч, стратегийн хяналт, удирдлага улам бэхжсэн.

Зээлийн багц (тэрбум төгрөг)



Зээлийн багц 230%-иар өсөж, нийт актив 27.3 тэрбум ₮ хүрч, өөрийн хөрөнгө ойролцоогоор 6.3 тэрбум ₮ хүрсэн нь компанийн санхүүгийн тогтвортой байдлыг мэдэгдэхүйц бэхжүүлж, цаашдын тогтвортой хөгжлийн бат бөх суурийг бүрдүүлж байна.



Гадаад эх үүсвэр



Triple Jump

Инвестор Санхүүгийн Байгууллага нь Нидерландын Triple Jump санхүүгийн байгууллагаас 5 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг амжилттай хүлээн авлаа.

Triple Jump нь ногоон болон тогтвортой хөрөнгө оруулалтын чиглэлээр дэлхийд тэргүүлэгч хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.



Инвестор Санхүүгийн Байгууллага нь олон улсын EMF Microfinance Fund хөрөнгө оруулалтын сангаас 3 сая ам.доллартай тэнцэх хэмжээний нэмэлт зээлийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ.

Ингэснээр тус сангаас Инвестор Санхүүгийн Байгууллагад олгосон нийт санхүүжилтийн хэмжээ 16 сая ам.доллар болж байна.




FMO

Entrepreneurial Development Bank

Инвестор Санхүүгийн Байгууллага нь Нидерландын Хөгжлийн Банк болох FMO-с 20 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Уг санхүүжилтийн 10 хувь нь ногоон болон тогтвортой бизнесүүдэд зориулагдах бөгөөд хөдөө аж ахуй, орон нутгийн бизнесүүд, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэнэ.

Энэхүү санхүүжилт нь Инвесторын хүртээмжтэй санхүүгийн үйл ажиллагааг өргөжүүлж, тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэж байна.



Triodos Bank

Инвестор ББСБ нь Triodos Investment Management-ээс 5 сая ам.долларын санхүүжилтийг татан төвлөрүүллээ. Энэхүү хөрөнгө оруулалт нь Монгол Улсад жижиг, дунд бизнесүүд болон санхүүгийн үйлчилгээний хүртээмж багатай бүлгүүдэд чиглэсэн хариуцлагатай санхүүгийн үйл ажиллагааг цаашид өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Triodos Investment Management нь тогтвортой хөгжил, хүртээмжтэй санхүүжилтийг дэмжих чиглэлээр Монгол Улсад урт хугацаанд үйл ажиллагаа явуулж буй сан юм. Энэхүү хамтын ажиллагаа нь хариуцлагатай зээл олголт болон урт хугацааны нийгмийн үр нөлөөг дэмжих нийтлэг зорилгыг илэрхийлж байна.



Хүний хөгжил, сургалт

Ажилтнуудын тоо:

Үндсэн ажилтны тоо
4%-иар өсөж 223 болов.

223

C-suite удирдлагын 60%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлж,
хүйсийн тэнцвэрийг бэхжүүлэхэд ахиц гаргав.

60%



Дотоод шилжилт, карьер хөгжил

Тайлант хугацаанд 10 ажилтан дотооддоо карьер ахиж, ахлах менежер, салбарын захирал болон газрын захирлын албан тушаалд дэвшин томилогдов. карьер ахиж боломжийг бүрдүүлэн ажиллалаа.



Сургалт хөгжилт

Компанийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, цалингийн төсвийн 3% хүртэлхийг ажилтнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулж байна.


Тайлант онд 136 ажилтан 1,384 цагийн сургалтад хамрагдаж, нэг ажилтанд ногдох дундаж сургалтын цаг 10.2 цаг болж өмнөх оноос өсөв.

Мэргэжлийн чиглэлийн сургалтуудыг зохион байгуулж, TalentLMS платформоор 1,643 цагийн онлайн сургалт явуулсан бөгөөд GGSF сангийн дэмжлэгээр жендерийн эрх тэгш байдлын олон улсын сургалтад 30 удирдах ажилтан хамрагдав.



Хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр

Ажилтнуудын урт хугацаанд тогтвортой ажиллуулах бодлогын хүрээнд 5 жилийн хугацаатай, үе шаттай хэрэгжих Хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн эхний шатыг хэрэгжүүлж эхлэв.





Ажилтны эрүүл мэнд



330

Бүх үндсэн ажилтныг 4 дэх жилдээ хувийн эрүүл мэндийн даатгалд хамруулж, 330 ажилтан нөхөн төлбөр авсан байна.

65

Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэв.

3 дахь жилдээ байгууллагын сэтгэл зүйч ажиллуулж, 65 ажилтан сэтгэл зүйн зөвлөгөө авсан.

Ажилтнуудын дуу хоолой, байгууллагын соёл



Жил бүр ажилтны сэтгэл ханамжийн судалгаа зохион байгуулж, үр дүнд нь үйл ажиллагаагаа сайжруулсаар байна.

Санал хүсэлт хүлээн авах нээлттэй сувгууд ажиллуулж, ажилтнуудын хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж байна.

Байгууллагын соёлыг тодорхойлсон “Соёлын ном” боловсруулж, нийт ажилтнуудад танилцуулав.

“Thank You” талархлын аян-аар 1,400+ талархал солилцож, эерэг соёлыг дэмжив.




03. Санхүүгийн үр дүн






Санхүүгийн үр дүн /Аудитлагдсан/


Нийт актив
тэрбум төгрөг




Цэвэр зээлийн багц
тэрбум төгрөг



Хүү шимтгэлийн орлого
тэрбум төгрөг




Цэвэр ашиг
тэрбум төгрөг




Санхүүгийн үр дүн /Аудитлагдсан/


Хөшүүрэг




Зээл активын харьцаа




Чанаргүй зээлийн харьцаа



Өөрийн хөрөнгийн өгөөж



Активын өгөөж



Зохистой үзүүлэлт	Босго	2025	Төлөв
Өөрийн хөрөнгө, Эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>20%	30.3%	Хангасан
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	>8%	43.3%	Хангасан
Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа	<80%	57.2%	Хангасан
Бондын харьцаа	<30%	23.3%	Хангасан



Хувьцаа




Ногдол ашиг

ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 13-ны өдрийн 08 тоот тогтоолоор Компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 114.9 төгрөгийн ногдол ашиг хуваарилж, нийт 8,701,402,980 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн 2026 оны 04-р сарын 17-ны өдрийн 21 тоот тогтоолоор ногдол ашиг тараах өдрийг 3 сар хүртэлх хугацаагаар буюу 2026 оны 07 сарын 31-ний өдөр хүртэл хойшлуулахаар шийдвэрлэсэн. Бүртгэлийн өдөр болон ногдол ашгийн хэмжээнд өөрчлөлт оруулаагүй болно.

Хуваарилсан ногдол ашгийн дүн (сая төгрөг)





04. Эрсдэлийн удирдлага





Эрсдэлийн удирдлага

“Инвескор ББСБ” ХК-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны гол зорилго нь эрсдэлийн төрөл тус бүрээр хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тодорхойлох, түүний хүрээнд эрсдэлийг үр дүнтэй, үр ашигтай удирдахад чиглэгддэг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд эрсдэлийг үр дүнтэй удирдах хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Хамгаалалтын 3 бүс

Инвескор ББСБ” ХК нь Хамгаалалтын 3 бүсийн зарчимд тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгон бизнесийн үйл ажиллагаатай уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж, хамгаалалтын бүс тус тодорхой чиг үүргийг гүйцэтгэдэг.

Хамгаалалтын 1-р бүс

Бизнес болон түүнд дэмжлэг үзүүлэгч нэгжүүд өөрийн хариуцаж буй үйл ажиллагаа, бизнесийн эрсдэлийг хариуцан үнэлэх, бууруулах, хянах, тайлагнах.

Хамгаалалтын 2-р бүс

Хууль, Эрсдэлийн удирдлагын газар нэгжүүд эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, журам зааврыг боловсруулах, шинэчлэх, эрсдэлийн хэм хэмжээг тогтоох, хянах, мониторинг хийх, зөвлөмжөөр хангах.

Хамгаалалтын 3-р бүс

Дотоод аудитын газар нь ТУЗ-д хараат бус баталгаажуулалтыг өгөх, үйл ажиллагааны үр дүнтэй байдалд хараат бусаар үнэлэлт дүгнэлт өгөх.

Эрсдэлийн соёл

Байгууллагын ажилтан бүр өөрийн чиг үүрэг, эрх хэмжээний, хариуцлагын хүрээнд үүсч болзошгүй эрсдэлийг тухай бүр таньж мэдэх, урьдчилан сэргийлэх, үнэлэх, бууруулах, холбогдох удирдлагад мэдээлэх болон батлагдсан хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг, оролцоог ханган ажиллаж байна.

Удирдлагын түвшинд эрсдэлийн удирдлагын бодлого, журам, аргачлалыг батлан мөрдүүлэх, дотоод хяналтын орчныг бэхжүүлэх, сургалт болон мэдээллээр тогтмол хангах замаар эрсдэлийн соёлыг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж байна.

Эрсдэлийн үнэлгээ

Инвескор ББСБ ХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог компанийн бизнесийн онцлог, процессын бүтэцтэй уялдуулан Эрсдэл ба хяналтын өөрийн үнэлгээ (RCSA)-ний аргачлалыг боловсруулж, удирдлагын түвшинд баталгаажуулсан. Тус аргачлалын хүрээнд болзошгүй эрсдэлийг системтэйгээр тодорхойлж, магадлал нөлөөллийн шалгуураар үнэлэн, эрсдэлийг бууруулах, хянах, шилжүүлэх болон хүлээн зөвшөөрөх зэрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Мөн эрсдэлийн тохиолдлыг мэдээлэх сувгийг дотоод системд хөгжүүлэн, нийт ажилтнууд эрсдэлийн тохиолдлыг цаг алдалгүй мэдээлэх боломжтой болж, бүртгэлжүүлсэн эрсдэлийн тохиолдолуудаар урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж байна.



Голлох эрсдэлүүд

Зээлийн эрсдэл

Инвескор ББСБ ХК нь зээлийн бодлого, журмыг боловсруулан, зээлийн эрсдэлийг удирдах нарийвчлан тодорхойлсон процесс, зээлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагатай хяналтыг бий болгож, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж зээлийн эрсдэлийг удирдах тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн үнэлгээний шалгуур, багцын төрөлжилт, зээлийн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан ба чанаргүй зээлийн түвшин, багцын төвлөрөл зэрэг гол үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, удирдлага болон ТУЗ-д тайлагнаж ажилладаг.

Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэл

2025 онд Инвескор ББСБ –ын зах зээлийн болоу хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүдийг байгууллагын хүлээн зөвшөөрөх хэмжээнд хангаж ажилласан бөгөөд зах зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад валютын нээлттэй позицийг зохистой түвшинд барих, эх үүсвэр болон активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, гадаад валют болон үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг тогтмол хянах замаар эрсдэлийг удирдан ажиллаж байна. Мөн макро эдийн засгийн төлөв байдлын шинжилгээний тайланг сар тутамд бэлтгэн холбогдох нэгжүүдэд хүргүүлж, бизнесийн болон санхүүгийн шийдвэр гаргалтад ашиглаж байна. Тайлант хугацаанд байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажилласан.

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл нь дотоод процесс, систем, хүний хүчин зүйл эсвэл гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр алдагдал үүсэх эрсдэлийг илэрхийлнэ. Байгууллага нь уг эрсдэлийг бууруулах зорилгоор дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх, стандартчилагдсан үйл ажиллагааны журам мөрдөх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулах, бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн үйл ажиллагааны эрсдэлийн тохиолдлыг тогтмол бүртгэн, дүн шинжилгээ хийж, нэгтгэн тайлагнах замаар удирдлагын шийдвэр гаргалтад ашиглаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Инвескор ББСБ ХК нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог олон улсын ISO/IEC 27001:2022 стандартад нийцүүлэн хэрэгжүүлж, тайлант хугацаанд хөндлөнгийн аудитад амжилттай хамрагдан баталгаажуулалтаа хадгалан ажилласан. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, систем болон аппликейшн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн процесст мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах шаардлагыг мөрдөж, дотоод систем, сүлжээ, сервер болон төгсгөлийн төхөөрөмжүүдийн аюулгүй байдлыг хамгаалах технологийн шийдлүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд мэдээллийн алдагдал болон кибер халдлагын эрсдэлийг бууруулах зорилгоор аюулгүй байдлын хяналт, мониторингийг тогтмол хэрэгжүүлж, эмзэг байдлын үнэлгээ, эрсдэлийн шинжилгээг тогтмол хийж, илэрсэн асуудлыг тухай бүр засварлан сайжруулж байна. Мөн мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам, сургалт болон соёлын арга хэмжээг хэрэгжүүлж, ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх замаар байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын соёлыг бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Комплаенс болон зохицуулалтын эрсдэл

Байгууллага нь зохицуулалтын орчны өөрчлөлтийг тогтмол хянаж, хууль, журамд нийцэж байгаа эсэхэд цогц хуулийн нийцлийн үнэлгээг жил бүр хийж, шаардлагатай хянан нийцүүлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, журамд нийцүүлэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, нийт ажилтнуудыг хамруулсан сургалтыг жил бүр зохион байгуулдаг. Тайлант хугацаанд зохицуулагч байгууллагуудад хүргүүлэх тайлан мэдээг хуульд заасан хугацаанд нь бэлтгэн хүргүүлж ажилласан.



05. Тогтвортой хөгжил





Тогтвортой хөгжил



Ногоон зээлийн хамтын ажиллагаа

2025 оны эхний хагаст Инвекор ББСБ нь ногоон зээлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагуудтай стратегийн түншлэлүүдийг бий болголоо. Тухайлбал, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж болон барилгын материалын үйлдвэрлэл, нийлүүлэлт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн нь бидний тогтвортой санхүүжилтийн зорилтод хүрэхэд түлхэц болж байна.



Тогтвортой эх үүсвэр

Инвекор ББСБ ХК нь хүртээмжтэй бөгөөд хариуцлагатай санхүүжилтийг дотоодын зах зээлд түгээж, нийгэм, эдийн засаг болон байгаль орчинд эерэг өөрчлөлт авчрах төсөл, санаачилгуудыг дэмжих зорилгын хүрээнд "Global Climate Partnership Fund" (GCPF), "Global Gender Smart Fund" (GGSF), мөн Нидерландын FMO банк зэрэг тогтвортой санхүүжилтийн сангуудаас ногоон болон жендерийн тэгш байдлыг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж, холбогдох хэлэлцээрийн бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Уг эх үүсвэрээр дамжуулан бид санхүүгийн үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, байгаль орчны хамгаалал, нийгмийн тэгш оролцоонд суурилсан тогтвортой санхүүгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахаар зорьж байна.



Тогтвортой байдлын туршлага

ТоС холбооны ББСБ-уудын мэргэжлийн зөвлөлийн ээлжит уулзалтын хүрээнд Инвекор ББСБ ХК нь тогтвортой хөгжлийн бодлого, түүний хэрэгжилт болон олон улсын стандартад нийцсэн тайлагналын туршлагаа бусад гишүүн байгууллагуудтай хуваалцлаа.



“Инвекор ББСБ” ХК нь НҮБ-ын Global Compact, Тогтвортой хөгжлийн 17 зорилго (SDGs), Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт (NDC) зэрэг олон улсын болон үндэсний бодлого, амлалт, зорилтуудтай үйл ажиллагаагаа уялдуулан, эдгээр зорилгын хэрэгжилтэд бодит хувь нэмэр оруулахыг зорин ажиллаж байна.

Бид 2025 онд тогтвортой санхүүжилтийн чиглэлээр дараах стратегийн алхмуудыг хэрэгжүүлэв.



Тогтвортой хөгжлийн бодлого

“Инвекор ББСБ” ХК нь Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбооны 2025 оны “Онцлох ТоС Санхүүгийн Байгууллага”-аар шалгарлаа.” Бид 2025 онд үйл ажиллагаандаа тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт, харилцагчийг хамгаалах, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр баримталсан бодлого, хэрэгжүүлсэн санаачилга болон өдөр тутмын манлайллаа ийнхүү өндрөөр үнэлүүлээ.



Жендэрийн эрх тэгш байдал

GGSF сангийн санхүүжилтээр 2025 оны 9 дүгээр сарын 17–18-ны өдрүүдэд жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр 2 өдрийн сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Сургалтаар санхүүгийн бүтээгдэхүүнд жендэрийн хандлагыг тусгах, байгууллагын дотоод засаглал болон эрсдэлийн удирдлагад жендэрийн үзүүлэлтүүдийг нэгтгэх чиглэлээр мэдлэг, чадавхыг бэхжүүлээ.



Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих

“Инвекор ББСБ” ХК нь ТоС холбооны Олон улсын RFT хөтөлбөрийн грантын хүрээнд бичил, жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих ногоон батлан даалтын тогтолцоонд хамтран оролцохоор гэрээ байгууллаа.

Энэхүү хамтын ажиллагаа нь жендэрийн хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чухал алхам боллоо.



06. Компанийн засаглал





Компанийн засаглал

Хувьцаа эзэмшлийн бүтэц ба хувьцаа эзэмшигчдийн оролцоо

Инвестор ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй, хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг компани юм.

Компани нь нийт 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцаатай бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчид нь дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчид, стратегийн болон жижиг хувьцаа эзэмшигчдээс бүрдэж байна. Үүнд:

- | | |
|-----------------------------------|---------------|
| • Эс Ай Би Жэй Капитал ХХК | 80.49% |
| • Олон нийт | 19.51% |

Компанийн засаглалын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэж, хариуцлагатай, ил тод, нээлттэй үйл ажиллагааг хангах үүднээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тогтмол зохион байгуулж, стратегийн ач холбогдол бүхий шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн оролцоотойгоор шийдвэрлэдэг.

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах зорилгоор танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгууллаа. Энэхүү хуралд саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид 90.11%-ийн ирцтэйгээр оролцсон ба дараах шийдвэрүүдийг 99.98%-ийн саналаар баталлаа. Үүнд:

- 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох;
- 2025 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
- 2023 оны 4 дүгээр сарын 14-ний хурлын А/04 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах

Компанийн Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд 100 ширхэг гацуур модны үрсэлгээ бэлэглэж, тарих боломжийг олгосон нь байгаль орчинд ээлтэй байх Компанийн үнэт зүйлсийг түгээх гол зорилготой байлаа.





Төлөөлөн удирдах зөвлөл /2025.12.31-ний байдлаар/

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 гишүүнийг улируулан томилж, шинээр 2 гишүүнийг сонгосноор ТУЗ нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгогдсон.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилоход гишүүдийн мэргэжлийн туршлага, хараат бус байдал, олон талт байдлыг хангах зарчмуудыг харгалзан үзсэн бөгөөд уг үйл явцад ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд үнэлгээ, дүгнэлт хийж Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулсан болно.



Б. Анхболд

Төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга



Д. Баясгалан

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Хирохито Намики

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Р. Пүрэв

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Ш. Эрдэнэбат

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Б. Энхмарал

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Ч. Хашчулуун

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн



Д. Энхбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн



Ч. Өнөржаргал


Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн



Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Компанийн засаглалын хүрээнд тайлант хугацаанд Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь компанийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор холбогдох дүрэм, журам, бодлогыг мөрдөж ажилласан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекс-т нийцүүлэн бүрдүүлсэн.

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Компани нь 5 төрлийн байнгын хороодыг байгуулан, хороо бүр гуравны хоёроос доошгүй төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэж байна. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 25/30 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсан.



Хороодын гишүүд /ТУЗ-ийн дэргэдэх хороод/

	Дарга	Гишүүд
Аудитын хороо	Ч. Хашчулуун	Ч. Өнөржаргал, Р. Пүрэв
Цалин урамшууллын хороо	Д. Энхбат	Ш. Эрдэнэбат, Ч. Өнөржаргал
Нэр дэвшүүлэх хороо	Ч. Хашчулуун	Д. Энхбат, Х. Намики
Эрсдэлийн удирдлагын хороо	Ч. Өнөржаргал	Б. Анхболд, Ч. Хашчулуун
Тогтвортой байдлын хороо	Д. Энхбат	Д. Баясгалан, Б. Энхмарал

Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур

Бизнес төлөвлөгөөнд тусгасан Тэнцвэржүүлсэн онооны систем дэх зорилтуудын биелэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин болон бусад урамшууллыг олгодог. Үүнд доорх 4 үндсэн бүлэг үзүүлэлтүүдийг багтаана.



Санхүүгийн тоон зорилтуудын биелэлт



Зах зээл, бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчийн үйлчилгээний зорилтуудын биелэлт



Дотоод процессын сайжруулалт, бизнес хөгжлийн үйл ажиллагааны зорилтуудын биелэлт




Хүний нөөц, бүтээмжтэй холбоотой зорилтуудын биелэлт



ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

	Бүрэлдэхүүн	2025 онд хуралдсан байдал	Хэлэлцсэн асуудал
ТУЗ-ийн хурал	Хурлын дарга: Б.Анхболд Хараат бус гишүүн: 3 Ердийн гишүүн: 6	Нийт 33 удаа хурал, 69 тогтоол • Эчнээ хурал – 23 удаа • Цахим хурал – 6 удаа • Биет хурал – 4 удаа	- Бизнес төлөвлөгөө, төсөв батлах - Компанийн бүтэц батлах - Үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, удирдлагын багийн гүйцэтгэлтэй танилцах - Гадаад болон ОУ-ын эх үүсвэр авах тухай - Үнэт цаас гаргах, нөхцөл тогтоох - Аудитын хорооноос дэмжсэн Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах - Охин компани байгуулах тэдгээрийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх - Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах - Компанийн дүрэмд заасан үнийн дүнгийн хэмжээгээр хөрөнгө захиран зарцуулах
Аудитын хороо	Хорооны дарга: Ч.Хашчулуун Гишүүн: Ч.Өнөржаргал Гишүүн: Р.Пүрэв	Нийт 19 удаа хурал, 37 дүгнэлт • Эчнээ хурал – 4 удаа • Цахим хурал – 13 удаа • Биет хурал – 2 удаа	- Дотоод хяналт, дотоод аудитын үйл ажиллагааны хяналт - Хөндлөнгийн аудит сонгох, хяналт тавих - Сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
Эрсдэлийн удирдлагын хороо	Хорооны дарга: Ч.Өнөржаргал Гишүүн: Ч.Хашчулуун Гишүүн: Б.Анхболд	Нийт 23 удаа хурал, 29 шийдвэр • Биет хурал – 2 удаа • Цахим хурал – 21 удаа	- Эрсдэлийн бодлого, аппетит - Эрсдэлийн тайлан - ТУЗ-өөс олгогдсон эрх хэмжээний хүрээнд зээл шийдвэрлэх
Тогтвортой байдлын хороо	Хорооны дарга: Д.Энхбат Гишүүн: Д.Баясгалан Гишүүн: Б.Анхболд	Нийт 1 удаа хурал, 1 дүгнэлт • Цахим хурал – 1 удаа	- БОНЗ тайлан - Ногоон санхүүжилтийн бодлого - БОНЗ чиглэлээрх хөрөнгө оруулалт
Цалин урамшууллын хороо	Хорооны дарга: Д.Энхбат Гишүүн: Ш.Эрдэнэбат Гишүүн: Ч.Өнөржаргал	Нийт 2 удаа хурал, 2 дүгнэлт • Цахим хурал – 1 удаа • Эчнээ хурал – 1 удаа	- Цалингийн бодлого, матриц - ТУЗ-ийн гишүүн, ГЗ, Удирдлагын багийн цалин, урамшууллыг тогтоох - Компанид урамшууллын систем хэрэгжүүлэх, дүгнэх
Нэр дэвшүүлэх хороо	Хорооны дарга: Ч.Хашчулуун Гишүүн: Д.Энхбат Гишүүн: Хирохито Намики	Нийт 1 удаа хурал, 1 дүгнэлт • Цахим хурал – 1 удаа	ТУЗ-ийн гишүүн, ГЗ-ийн ажлын туршлага, ур чадварыг дүгнэх, нэр дэвшүүлэх

InvesCore FI



+976 7709-0077

info@invescore.mn

www.invescore.mn